



ХЭНТИЙ АЙМГИЙН ЖАРГАЛТХААН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/26


Жаргалтхаан сум

Төрөлжсөн сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3, 33.3.7 дахь заалт, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.11, 20 дугаар зүйлийн 20.5, 20.7, 20.8, 20.9 дэх заалт, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2024 оны А/262 дугаар тушаал, Жаргалтхаан сумын ерөнхий боловсролын сургуулийн зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 08 – ны өдрийн 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Математикийн мэргэжлийн багш нарын дүгнэлтийг үндэслэн 6а ангид сургуулийн түвшинд төрөлжсөн сургалтыг зохион байгуулсугай.
2. Төрөлжсөн сургалт зохион байгуулах журмыг хавсралтаар баталсугай.
3. Төрөлжсөн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулж, сургалт зохион байгуулж байгаа багшийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллахыг сургалтын менежер (Д.Бямбадорж)-д үүрэг болгосугай.
4. Сургалт зохион байгуулсан багш, анги удирдсан багш, удирдах ажилтны нэмэгдэл хөлс болон бусад зардлыг зохих журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч (Г.Урансүх)-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



С.ОЮУНЦЭЦЭГ

D/Tushaal-2025

232501051